

## ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН СУДАЛГАА, ДҮГНЭЛТ /ОРХОН АЙМГИЙН ЖИШЭЭГЭЭР/

Д.Нямаа\*, Э.Баттуяа\*\*, Б.Баясал\*\*\*

**Хураангуй:** Хөдөө аж ахуйн салбар нь манай орны уламжлалт салбар бөгөөд 2023 оны эхний хагас жилийн байдлаар хөдөө аж ахуйн салбар (Үндэсний статистикийн хороо, 2023) дотоодын нийт бүтээгдэхүүний 12 хувийг эзэлж байгаа бол экспортын орлогын 6 хувь, ажиллах хүчний 26 хувь тус салбарт хамаарч байна. Сүүлийн 10 жилд ХХААХҮ-ийн сайдын багцын төсвийн нийт зарлага нь 2011 онгйг эс тооцвол ДНБ-ий 0,2-1,6 хувь, нэгдсэн төсвийн 0,8-4,2 хувь, улсын төсвийн 1,1-5,5 хувийг тус тус эзэлж байна. ХХААХҮ-ийн салбарт улсын төсвөөс санхүүжүүлсэн нийт дэмжлэг, урамшууллын хэмжээ 2010-2022 оны дунджаар тус салбарын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн 34,3 хувь, урсгал зардлын 46,9 хувийг тус тус эзэлж, салбарын төсөвт томоохон жин дарж байна. Тиймээс Орхон аймгийн газар тариалангийн салбарт төсвийн дэмжлэгийг үр дүнтэй ашиглахын тулд Монгол улсын хөдөө аж ахуйг дэмжих бодлого, төсвийн дэмжлэг, урамшуулал буюу татаас шилжүүлгийн өнөөгийн байдал, хэрэгжүүлж буй арга хэлбэр, түүний үр нөлөө, үр дүнд шинжилгээ хийх, төсвийн зардлыг илүү үр дүнтэй, үр ашигтай зарцуулах шаардлагатай байна.

**Түлхүүр үгс:** Хүнс Хөдөө Аж Ахуй Хөнгөн үйлдвэрийн салбар, Үндэсний Статистикийн Хороо, газар тариалан, газар тариалангийн салбарын хүчин зүйлийн шинжилгээ

## ANALYSIS OF THE CURRENT STATE OF INVESTMENT IN THE AGRICULTURAL SECTOR: EVIDENCE FROM ORKHON PROVINCE

**Abstract:** Agriculture is a traditional branch of our country and the Agriculture al sector comprises of (Committee for Statistics. 2023) 12 % of total gross domestic product in the first half of 2023, while 6 % of export income and 26% of the workforce are in the sector. Over the past 10 years, the total budget expenditure of the Ministry of Food and Agriculture has been 0.2-1.6 % of GDP, 0.8-4.2% of the combined budget, and 1.1-5.5% of the state budget. The total support and incentives funded by the state budget for the Food and Agriculture Industry industry are overweight in the branch budget, accounting for 34.3% of the total budget expenditure and net loans for 2010-2022, and 46.9% of the flow costs.

Therefore, in order to use the budget support in the agricultural sector in Orkhon province, it is required to do analysis in the current state of the Mongolian governmental policy to support agriculture, budget support, incentives or tax dotation transfers, and to spend and utilize budget costs efficiently.

**Keywords:** Food, Agriculture and light industry, Agriculture, Factor Analysis of Agricultural sector

<sup>1</sup> МУИС. Бизнесийн сургууль. (E-mail): [d.nyamaa@num.edu.mn](mailto:d.nyamaa@num.edu.mn)

<sup>2</sup> “Эрдэнэт цйлдвэр” ТӨҮГ-ын дэргэдэх, ШУТИС-ийн харьяа Эрдэнэт цогцолбор дээд сургууль. (E-mail) : [z.battuya11@gmail.com](mailto:z.battuya11@gmail.com)

<sup>3</sup> “Эрдэнэт цйлдвэр” ТӨҮГ-ын дэргэдэх, ШУТИС-ийн харьяа Эрдэнэт цогцолбор дээд сургууль. (E-mail) : [b.bayasal1225@gmail.com](mailto:b.bayasal1225@gmail.com)

## АГУУЛГА

### Судалгааны зорилго:

Энэхүү судалгааны ажлын зорилго нь салбарын бодлого, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан улсын болон орон нутгийн төсвийн урамшуулал, дэмжлэгийн хэрэгжилт, өнөөгийн байдалд шинжилгээ хийж дүгнэлт өгөх.

### Судалгааны зорилт:

- Орхон аймгийн газар тариалангийн салбарын статистик, тоон мэдээллийг цуглуулж, нэгтгэх, харьцуулан дүгнэлт гаргах;
- ХАА-н салбарын урамшуулал, дэмжлэгийн бодлогын үр өгөөж, үр дүнтэй байдлыг үнэлж дүгнэх;
- Газар тариалангийн салбарт нөлөөлөгч хүчин зүйлсийг байгаль орчин, эдийн засаг, нийгмийн хүчин зүйл, дотоод нөөц боломж, оролцогч талуудын нөлөө гэсэн 5 бүлэг 28 асуулгаар тодорхойлж үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжүүдээс судалгаа авах.

### Газар тариалангийн салбарын өнөөгийн байдал

Орхон аймаг нь Монгол орны ойт хээрийн бүсэд Хангайн нурууны салбар уулс, Бүрэнгийн нурууны өвөрт Орхон, Сэлэнгийн сав газарт далайн түвшнээс дээш 1200 метрийн өндөрт оршдог. Аймгийн хөдөө аж ахуйн эдэлбэр газар нь 46281.2 га бөгөөд 39441 га бэлчээр, 1400 га хадлангийн талбай, 269.5 га атаршсан газар, 5077.65 га тариалангийн талбай байна. Тариалангийн талбайн 5065.95 га буюу 99.7 хувь нь Жаргалант суманд, 11.7 га буюу 0.3 хувь нь Баян-Өндөр суманд тус тус харьяалагддаг.

Орхон аймгийн хувьд 2022 оны байдлаар хаврын тариалалтаар 4779.0 га-д үр тариа, 272.6 га-д төмс, 503.2 га-д хүнсний ногоо, 283.9 га-д малын тэжээл, 9.9 га-д жимс, жимсгэнэ тариалснаар төлөвлөгөөт зорилт үр тарианы хувьд 110.1 хувь, хүнсний ногоо 121.8 хувь, малын тэжээл 88.7 хувь, төмс 79.5 хувьтай биелсэн байна. Тариалсан талбайн нийт хэмжээ өмнөх оноос 11.6 хувиар нэмэгджээ.

Тайлант онд 4339.0 га-аас 11508.6 тн үр тариа, 272.6 га-аас 3150.0 тн төмс, 503.2 га-аас 7325.4 тн хүнсний ногоо хураасан нь өмнөх оноос хураан авсан хүнсний ногоо 25.3 хувиар их, харин үр тариа 14.9 хувиар, төмс 3.3 хувиар бага байна. (Орхон аймгийн ХХААГ-ын 2022 оны тайлан)

Тариалан эрхэлсэн өрхийн тоо 2021 онд 884 байсан бол 2022 онд 462 болж 52,3 хувиар буурсан, аж ахуйн нэгж, байгууллагын тоо 2021 онд 11

байсан бол 2022 онд 14 болж, өмнөх оноос 3-аар буюу 27,3 хувиар нэмэгдсэн байна. Тариалан эрхэлсэн өрх, аж ахуйн нэгж, байгууллагын тоог Хангайн бүсийн 2018-2022 оны дундажтай харьцуулахад өрхийн тоо 24 хувь, аж ахуйн нэгж, байгууллагын тоо 4 хувийг эзэлж байгаа нь доогуур үзүүлэлттэй буюу ялангуяа аж ахуйн нэгж, байгууллагын тоог цаашид нэмэгдүүлэх шаардлагатай байна. (хороо, <https://www.1212.mn/mn/statistic/file-library/bulletin>, 2023)

*Зураг 1. Орхон аймгийн газар тариалангийн салбарын 2018-2022 оны тариалан эрхэлсэн өрх, ААНБ-ын тоо*



*Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.  
Газар тариалан 2022 оны 12 сарын 31*

Газар тариалангийн салбарын байнгын ажлын байрны тоонд 5 жилийн байдлаар төдийлөн өөрчлөлт гараагүй нь газар тариалан эрхэлж байгаа ААНБ-ын тоотой шууд хамааралтай байгааг харуулж байгаа ба улирлын шинж чанартай ажлын байрны тоо 2021 онд 1125 байсан бол 2022 онд 980 болж 13 хувиар буурсан байна. (ХХААГ, 2018-2022)

### **Тариалалт, га:**

Тариалсан талбайг ургамлын нэр төрлөөр 2022 оны байдлаар авч үзвэл, өмнөх оноос, үр тариа 252 га-гаар буюу 6.4 хувиар, хүнсний ногоо 21.4 га-гаар буюу 5.7 хувиар, малын тэжээл 371.6 га-гаар буюу 627.7 хувиар өссөн, төмс 46.5 га-гаар буюу 12.7 хувиар буурсан харин даршны ургамал, техникийн ургамал, жимс, жимсгэнийг тухайн онд тариалаагүй байна.

*Хүснэгт 1. Орхон аймгийн газар тариалангийн салбарын  
2018-2022 оны тариалалт, га*

№	Төрөл		Огноо			
	2018	2019	2020	2021	2022	
1	Үр тариа	4,334.0	3,361.5	3,832.5	3,940.0	4,192.0
	Улаан буудай	4,300.0	3,350.5	3,832.5	3,890.0	4,149.0
	Овьёос	0.0	11.0	0.0	20.0	43.0
	Хөх тариа	15.0	0.0	0.0	0.0	0.0
	Арвай	17.0	0.0	0.0	30.0	0.0
	Бог будаа	2.0	0.0	0.0	0.0	0.0
2	Төмс	469.2	350.1	342.6	365.7	319.2
3	Хүнсний ногоо	286.8	316.5	283.0	372.5	393.9
4	Малын тэжээл	122.2	141.3	212.0	59.2	430.8
5	Даршны ургамал	10.0	0.0	0.0	7.0	0.0
6	Техникийн ургамал /рапс/	60.0	85.0	270.0	60.0	0.0
7	Жимс, жимсгэнэ	2.1	12.3	4.2	4.0	0.0
<b>Бүгд</b>		<b>5,284.3</b>	<b>4,266.7</b>	<b>4,944.3</b>	<b>4,808.4</b>	<b>5,335.9</b>

*Эх сурвалж: Орхон аймгийн статистикийн 2018-2022 оны тайлан*

### **Ургац хураалт:**


Орхон аймгийн хэмжээнд 2022 онд үр тариа 13,526 тонн, төмс 3,257.4 тонн, хүнсний ногоо 5,847.5 тонн, таримал тэжээл 2,094.5 тонн, даршны ургамал 430 тонныг хураан авч, сүрэл 300,4 тонн, хужир шүү 340.1 гар тэжээл 109.2 тонныг бэлтгэсэн байна. Өмнөх оноос хураасан үр тариа 3,327.9 (33%) тонн, хүнсний ногоо 24.8 (0.4%) тонн, тэжээлийн ургамал 690.6 (49,2%) тонн, даршны ургамал 29.0 (7,2%) тонн, бэлтгэсэн гар тэжээл 109.2 (145%) тонн, сүрэл 12.6 (4.4%) тонн, хужир шүү 85.1 (33.4%) тонн, гар тэжээл 109.2 (145%) тонноор тус тус өсөж, харин хураасан төмс 1,250.5 (27.7%) тонноор буурсан байна.

Нийт хураасан үр тарианы 98 хувийг улаан буудай, 2 хувийг овьёос эзэлж байна.

### **Га-гийн ургац:**

Нэг га-гаас дунджаар 2022 онд 33.1 центнер үр тариа, 102.0 центнер төмс, 148.5 центнер хүнсний ногоо хураан авсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад нэг га-гаас авсан үр тариа 6.6 центнер буюу 24.9 хувиар, төмс 21.3 центнер буюу 17.3 хувь, хүнсний ногоо 7.8 центнер буюу 5 хувиар тус тус буурч, харин хураан авсан тэжээлийн ургамал, даршны ургамал бэлтгэсэн сүрэл, хужир шүү, гар тэжээл өссөн байна.

Зураг 2. Ургац хураалт ургамлын нэр төрлөөр, 1 га-аас



Эх сурвалж: Орхон аймгийн ХХААГ-ын 2018-2022 оны тайлан

Хүлэмжийн аж ахуйгаас хураан авсан ургац нь 2021 онд зуны хүлэмжээс 2022 онд 18 хувиар, өвлийн хүлэмжээс 200 хувиар өссөн байна.

### Усалгаатай талбай:

Аймгийн хувьд 2020 оныг өмнөх онтой харьцуулахад 115.7 га буюу 22 хувиар нэмэгдсэн. Улс, бүсийн усалгаатай талбайн сүүлийн 5 жилийн дундажтай харьцуулахад улсын дүнд 1.3 хувь, бүсийн дүнд 10 хувийг эзэлж байна.

Зураг 3. Усалгаатай талбайн тариалалт, улс, бүс, аймаг, га



Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.

Усалгаатай талбайг ургамлын төрлөөр нь авч үзвэл үр тариа тариалалтын талбай 2018 онд 90 га газар байсан бол сүүлийн 3 жилд байхгүй байна. Иймд цаашид үр тариа тариалж байгаа газар тариалангийн усалгаатай талбайг нэмэгдүүлэх шаардлагатай гэж харагдаж байна.

Усалгаатай талбай 2020 оныг 2021 онтой харьцуулахад төмсний тариалалтын талбайн усалгаа 6 хувиар, хүнсний ногооны тариалалтын талбайн усалгаа 3 хувиар буурсан байна.

Зураг 4. Усалгаатай тариалангийн талбай ургамлын төрлөөр, га



Эх сурвалж: Орхон аймгийн ХХААГ-ын 2018-2022 оны тайлан

Газар тариалангийн салбарт тулгарч буй асуудал, сорилт (Хөдөө аж ахуйн дэмжлэг, урамшууллын судалгааны тайлан)

Тус салбарт ойрын хугацаанд дараах сорилт тулгарч байна. Үүнд:


- Байгаль, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэл өндөр.
- Усалгаатай тариалангаас бусад тариалангийн ургац цаг уурын нөхцөлөөс маш өндөр хамааралтай.
- Шинэ технологи, инновацын нэвтрэлт удаан, техник тоног төхөөрөмжийн хангамж сайнгүй. бүтээмж, үр ашиг доогуур байна.
- Хүнсний ногооны дотоодоос нийлүүлэх үрийн хэмжээ нийт хэрэгцээг хангахгүй, импортын өндөр хамааралтай байна.
- Төмс, хүнсний ногоог хадгалах зоорь, агуулах хангалтгүй байгааг шийдэх эдийн засгийн арга, хэрэгслийг ашиглах
- Тээвэр, логистикийн үйлчилгээг сайжруулах шаардлагатай байна.

### Хөрөнгө оруулалт, дэмжлэг тусалцаа, хэрэгжүүлсэн ажил:

Орхон аймгийн хувьд орон нутгийн онцлогт тохируулан «Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр»-ийг боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 63 дугаар тогтоолоор 4 зорилт, 62 үйл ажиллагаа бүхий дэд хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг жил бүр аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралд тайлагнан ажиллаж байна.

Аймгийн Засаг Даргын 2017-2022 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлд оруулсан хөрөнгө оруулалт дараах байдалтай байна. (Орхон аймгийн ХХААГ-ын 2017-2022 оны жилийн гүйцэтгэлээр тайлан)

Зураг 5. Газар тариалангийн үйлдвэрлэлд оруулсан хөрөнгө оруулалт, мян.төгрөг




Эх сурвалж: Орхон аймгийн ХХААГ-ын 2017-2022 оны жилийн гүйцэтгэлийн тайлан

Газар тариалангийн үйлдвэрлэлд хийгдсэн хөрөнгө оруулалт 2018 оноос хойш тогтмол өссөн нь тухайн салбарт төрөөс хэрэгжүүлж буй олон төсөл хөтөлбөрүүдтэй холбоотой бөгөөд 2022 оны хөрөнгө оруулалтыг өмнөх оныхтой харьцуулахад 34.5 сая төгрөгөөр буюу 14.7 хувиар өссөн байна.

Тариалангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны “Мөнгөн урамшууллын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 15 дугаар тогтоолын дагуу Орхон аймгийн тариалан эрхлэгчид улаан буудай нийлүүлж дараах мөнгөн урамшууллыг авсан байна.

Зураг 6. 2017-2020 онд авсан буудайн урамшуулал, сая төгрөг



Газар тариалангийн салбарын дэмжлэг, урамшууллын байдалд хийсэн судалгаа, дүгнэлт:

Бид 2022 онд Орхон аймгийн ЗДТГ-ын захиалгаар “Орхон аймгийн ХАА-н салбарт нөлөөлөгч хүчин зүйл”-ийн судалгааг хийсэн ба тус аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумын төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал тариалдаг 154 тариаланчийг санамсаргүй түүвэрлэлтийн аргаар сонгон анкетын судалгаа авч, уулзалт, ярилцлага хийсэн.

Уг өгүүлэлд дээрх судалгааны нэг хэсэг болох дэмжлэг, урамшуулалтай холбоотой асуулга судалгааны үр дүнг оруулсан болно.

Судалгаанд хамрагдагчдыг ангилан авч үзвэл 92.2% нь төмс, хүнсний ногоо тариалагч хувь иргэн, 3.9% нь хоршоо, 3.9% нь компанийн төлөөлөл байна.

Орхон аймгийн хэмжээнд тариалан эрхэлдэг 462 өрх байгаагаас судалгаанд 154 өрх, үр тарианы 14 компани үйл ажиллагаа явуулдаг 10 компани, 2 хоршоолол тус тус хамрагдсан ба газар тариалан эрхлэгчдийн тариалсан ургацыг ургамлын төрлөөр нь авч үзвэл төмс, хүнсний ногоо зонхилох хувийг эзэлж байна.

Зураг 7. Тариалсан ургамлын төрөл, ангилал



Судалгаанд хамрагдсан 154 тариаланчаас улаан буудайн урамшуулалд 23 нь хамрагдсан, 130 нь хамрагдаагүй байна. Тариаланчдаас ХАА-н дэмжлэг, урамшуулалд хамрагдаж чадаагүй шалтгааныг нь асуухад 40 хувь нь дэмжлэг, урамшууллын талаар мэдээлэлгүй, 23 хувь нь талбайн хэмжээ бага эсвэл түрээсийн талбайтай учраас хамрагдаж чадаагүй, 15 хувь нь олон тооны бичиг баримт шаарддаг, шат дамжлаг их, 14 хувь нь бичиг баримт, мэдээллийн зөрүүтэй байдлаас шалтгаалан урамшуулаа авч чадаагүй, 7 хувь нь урамшуулалд хамрагдах хугацаанд бичиг баримтаа бүрдүүлж өгч чадаагүй гэж хариулсан байна.



Зураг 8. Тариаланчдын ХАА-н дэмжлэг, урамшуулалд хамрагдаж чадаагүйн шалтгаан



Асуулга судалгааны хүрээнд үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжүүдээс газар тариалангийн салбарт нөлөөлөгч хүчин зүйлсийг байгаль орчин, эдийн засаг, нийгмийн хүчин зүйл, дотоод нөөц боломж, оролцогч талуудын нөлөө гэсэн 5 бүлэг 28 асуулгаар судлан үнэллээ.

Нөлөөлөх үнэлгээг хүчин зүйл тус бүрээр сонгон авч 1-5 оноогоор үнэлэв. Хүчин зүйлийн нийлбэр оноо нь

- 1-1.79 маш муу,
- 1.8-2.59 муу,
- 2.6-3.39 дунд зэрэг,
- 3.4-4.1 сайн,
- 4.2-5.0 маш сайн нөлөөтэй гэж үзнэ.

Газар тариалангийн салбарт нөлөөлөгч хүчин зүйлийг дараалалд оруулан үнэлбэл.

1. “Оролцогч талуудын нөлөө” -1.9 оноо,
2. “Эдийн засгийн хүчин зүйлийн нөлөө” -2.2 оноо
3. “Дотоод нөөц боломж -2.3 оноо
4. “Нийгмийн хүчин зүйлийн нөлөө -2.43 оноо
5. “Байгаль орчны нөлөө” -2.5 оноо тус тус авсан байна


Зураг 9. Газар тариалангийн салбарт нөлөөлөгч хүчин зүйлс



“Маш муу” үнэлгээтэй нь оролцогч талуудын нөлөө бүлэг (1.9) : Орхон аймгийн газар тариалангийн салбарын оролцогч талууд болох засгийн газар, холбогдох яам, орон нутгийн засаг захиргааны байгууллагын дэмжлэг төсөл хөтөлбөр, ОУ-ын болон төрийн бус байгууллагууд, банк санхүүгийн байгууллага, ХАА-н тоног төхөөрөмж түрээслэгч, борлуулагч аж ахуйн нэгж, ХАА-н анхдагч түүхий эд ашиглагч байгууллагууд болон газар тариалангийн аж ахуй эрхлэгчдийн хамтын ажиллагаа, оролцоо муу байгааг судалгааны үр дүн харуулж байна.

“Муу” үнэлгээтэй нь байгаль орчны нөлөө бүлэг (2.5) : Орхон аймгийн газар тариалан эрхлэгчдэд байгаль, цаг уурын нөлөөлөл, хөрсний элэгдэл, дэлхийн дулаарал, ургамал хамгааллын бодисын зохисгүй хэрэглээ, цагаан тоосны дэгдэлт, хор уршиг өнөөгийн байдалд муу гэсэн үзүүлэлтэй байгаа боловч бусад 4 -н хүчин зүйлсээс Лайкерт шкалын аргын үнэлгээ нь өндөр байгаа нь тариалан эрхлэгчдэд сөрөг нөлөөлөл нь харьцангуй бага гэж үзэж байна.

Зураг 10. Газар тариалангийн салбарт нөлөөлөгч хүчин зүйлс, ангилал



- ✓ Хүчин зүйлсийг үнэлэх шинжилгээнд газар тариалангийн салбарын аж ахуй эрхлэгчдэд байгаль, цаг уурын нөлөөлөл (дочир хүйтрэлт,

ган, мөндөр) дэлхийн дулаарал, ургамал хамгааллын бодисын зохисгүй хэрэглээ, дундын борлуулагчдын (ченжүүд) оролцоо, нөлөө гэсэн хүчин зүйлүүд Лайкертын үнэлгээгээр дунд буюу салбарт төдийлөн сөргөөр нөлөөлөхгүй ч эерэг нөлөө үзүүлээгүй гэж тооцно.

Зураг 11. Газар тариалангийн салбарт нөлөө үзүүлсэн хүчин зүйлс



- ✓ Үнэлгээний 28 үзүүлэлтийн үр дүнд “Сайн” болон “Маш сайн” үнэлгээтэй хүчин зүйл гараагүй тул өнөөгийн газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжид өндөр ач холбогдол бүхий хүчин зүйл байхгүй байна.


Хүчин зүйлүүдийн нөлөөллийн хүчийг тогтоох зорилгоор корреляцийн шинжилгээг хийсэн бөгөөд газар тариалангийн салбарт нөлөөлөх 28 хүчин зүйлсийг хамруулсан уг үзүүлэлтэд эерэг хүчтэй нөлөөлсөн 5 хүчин зүйл, сөргөөр нөлөөлсөн 6 хүчин зүйл байна

Орхон аймгийн газар тариалан эрхлэгчдэд эергээр нөлөөлөх 5 хүчин зүйлд усалгаа, усалгааны системийн байдал, эрдэс бордооны хангамж хүрэлцээ, чанарын шаардлага хангасан үр тарианы олдоц нийлүүлэлт, бүтээгдэхүүн борлуулах цэг салбарын хүрэлцээ, орон нутгийн засаг захиргааны байгууллагын дэмжлэг төсөл хөтөлбөр зэрэг үзүүлэлтүүд салбарын иргэн, аж ахуйн нэгжид эергээр нөлөөлж болох үзүүлэлт болсон байна.

Улс, аймаг, сумдын хөрөнгө оруулалтаар “Хүнсний ногоо үндэсний хөтөлбөр”, «Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн» үндэсний хөтөлбөр, 10-н их наядын зээлийн хөтөлбөр, “Өрхийн тариалалтыг дэмжих» хөтөлбөр, “Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ үндэсний хөтөлбөр» “Жаргалантын ногоочид» дэд хөтөлбөрүүд аймгийн тариалан эрхлэгчдэд үр дүнгээ өгсөнтэй холбоотой байна.

“Өрхийн тариалалтыг дэмжих» хөтөлбөрийн хүрээнд төмс, хүнсний ногооны үрийг аймгийн ногоочдод 80% хөнгөлөлтэй үнээр өгч байгаа нь тэдний үйл ажиллагаанд томоохон дэмжлэг болж чадсан байна. Мөн Жаргалант сумын ногоочдод хөтөлбөрийн хүрээнд *усалгааны иж бүрдэл болох усны мотопомп, намираа шланк, холбох хэрэгсэл бүхий 10 бүрдэл тоног төхөөрөмж нийлцүлэгдсэн*. Аймгийн хэмжээнд инженерийн хийцтэй 144, энгийн 97, нийт 241 худаг, уст цэг ажиллаж байна.

Зураг 12. Газар тариалангийн салбарт эерэг нөлөө үзүүлсэн хүчин зүйлс



Газар тариалангийн салбарт аж ахуй эрхлэгчдэд инфляцын нөлөө, шатахууны үнийн өсөлт, тариалалтын талбайн хэмжээ, хүрэлцээ, цагаан тоосны дэгдэлт, хор уршиг, дэлхийн дулаарал, байгаль, цаг уурын нөлөөлөл (цочир хүйтрэлт, ган, мөндөр) зэрэг хүчин зүйлүүд шууд сөрөг нөлөө үзүүлсэн байна. Сөрөг нөлөө үзүүлэгч хүчин зүйлүүдээс цагаан тоосны дэгдэлт хамгийн өндөр буюу 32%-ийг эзэлж байгаа Орхон аймгийн хувьд энэ нь маш том анхаарал татсан асуудал болоод байна. Цагаан тоос нь зөвхөн газар тариаланд бус мал аж ахуй, хүний эрүүл мэндэд ч хор хөнөөлөө учруулаад байна. Байгаль цаг уурын нөлөөлөл нь 21%-ийг эзэлж байна. Энэ нь тариаланч аж ахуйн нэгж, иргэд өөрсдөөс нь шалтгаалах хүчин зүйл юм. Эрсдэлийг тооцоолж бизнесийн үйл ажиллагаандаа гадаад орчноос нөлөөлөх хүчин зүйлийн нөлөөллийг маш сайн тооцоолж, хариу үйлдлийг төлөвлөгөөтэй, бодлоготой хэрэгжүүлэх нь үр дүнтэй юм.

Манай улсын хэмжээнд сүүлийн жилүүдэд шатахуун, дизель түлшний үнэ өссөн нь үр тариа, малын гэжээл тариалалт, төмс, хүнсний ногооны хураалтын зардал өссөн нь цаашид тогтвортой үйл ажиллагаа эрхлэхэд сөргөөр нөлөөлж байна. Орхон аймаг ХАА-н эдэлбэр газар бага, тариалалт хийх талбайн хүрэлцээ муутай үйлдвэрлэлээ өргөжүүлэх ургацын хэмжээг нэмэгдүүлэхэд хамгийн их саад тотгор болдог байна.

Инфляц нь төв банкны зорилтот түвшин болох  $6\pm 2$  хувийн интервалыг давж, улсын хэмжээнд 14.4 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 15.2 хувьд хүрч өсөөд байна. Энэ нь газар тариалан эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгжүүдэд шатахууны үнэ, импорттоор авдаг хөдөө аж ахуйн сэлбэг хэрэгслийн хор бордооны үнийн өсөлт нь зардлын өсөлтийг бий болгосон

Зураг 13. Газар тариалангийн салбарт сөрөг нөлөө үзүүлсэн хүчин зүйлс



### Регрессийн шинжилгээ, үр дүн

Газар тариалангийн салбарын өндөр урамшуулал олгосон үр тарианы үйлдвэрлэлийг сонгон авч шинжилгээг хийсэн ба үр тарианы үйлдвэрлэлд тариалсан талбайн хэмжээ, нэг центрээс хураасан ургацын хэмжээ, үр тарианы зах зээлийн үнэ, урамшуулал хэрхэн нөлөөлж буйг судлах зорилготой. Энэ үйлдвэрлэлийн функцэд бодлогын сонирхсон хувьсагчдыг нэмж, тооцоолол хийх боломжтой байдаг. Шугаман тэгшитгэлийн коэффициентийг тооцоход хялбар Кобби Дугласын үйлдвэрлэлийн функцийг (Кобби-Дугласын үйлдвэрлэлийн Функц (Nastis et al, 2012)) логаритм хэлбэрийг сонгон ашигласан.

#### Шинжилгээний функцийг загвар:

$$Y_t = -0.319 + 0.605 * X_1 + 0.0585 * X_2 + 1.30 * X_3 + 0.334 * X_4 + u_t$$

(1.96)                      (0.256)                      (0.137)                      (0.436)                      (0.211)

$Y_t$  t жилд аймгийн бэлтгэсэн үр тариа

$X_1$  t жилд аймгийн тариалсан талбай

$X_2$  t жилд аймгийн 1 га-гийн ургац

$X_3$  t жилд аймгийн тариаланчдын тоо

$X_4$  t жилд аймгийн үр тариа бэлтгэлд олгосон урамшуулал

Summary Statistics, using the observations 2009 - 2022

	Mean	Median	S.D.	Min	Max
Yt	7993	6791	2890	2746	13526
X1	2751	2715	878.9	1619	4779
X2	13.59	10.85	8.484	5.700	33.10
X3	9.429	9.500	1.453	7.000	12.00
X4	75.41	78.00	22.07	50.00	100.8

Энэхүү шинжилгээнд 2009-2022 онд аймгийн хураасан үр тариа, тариалсан талбайн хэмжээ, нэг га газраас авсан ургац, олгосон урамшууллын мэдээллийг ашигласан.

2009-2022 онд жилд дунджаар 7,993 мянган тонн үр тариа хураасан бөгөөд хамгийн ихдээ 13,526 мянган тонноос 2,746 мянган тонн хооронд хэлбэлзэж байна. Жилд дунджаар нэг га талбайгаас 13,6 центнер үр тариа хураасан байна. Аймагт жилд дунджаар 75.4 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.

Model 1: OLS, using observations 2009-2022 (T = 14)  
Dependent variable:  $L_{Yt}$

	Coefficient	Std. Error	t-ratio	p-value
const	-0.318559	1.95962	-0.1626	0.8745
L_X1	0.604800	0.255806	2.364	0.0423 **
L_X2	0.0585107	0.137391	0.4259	0.6802
L_X3	1.29880	0.435535	2.982	0.0154 **
L_X4	0.333836	0.211330	1.580	0.1486

Mean dependent var	8.917617	S.D. dependent var	0.403585
Sum squared resid	0.457251	S.E. of regression	0.225401
R-squared	0.784056	Adjusted R-squared	0.688081
F(4, 9)	8.169380	P-value(F)	0.004576
Log-likelihood	4.085922	Akaike criterion	1.828157
Schwarz criterion	5.023444	Hannan-Quinn	1.532375
rho	0.242684	Durbin-Watson	1.467451



**Регрессийн шинжилгээний** R-squared, adjusted R, F-statistics үзүүлэлтээс үзэхэд шинжилгээ найдвартай байна. Онолын хувьд болон эмпирик судалгаагаар тогтоосны дагуу урамшуулал гэсэн хүчин зүйл эерэг нөлөөтэй боловч статистикийн хувьд найдвартай биш гэж **гэж гарч байна**.

R-squared 78 хувь засварласан дитерминацийн коэффициент 68 хувь байгаа нь сонгож авсан 4 хүчин зүйл нь хураасан ургацын өөрчлөлтийн 78 хувийг тайлбарлаж байна гэж үзнэ. Харин 22 хувь нь бусад хүчин зүйлээс хамааралтай байна. F-statistics нь миний сонгосон 4 хүчин зүйлээс 2 хүчин зүйл нь эерэг нөлөөтэй буюу статистикийн хувьд ач холбогдолтой. Энэ нь тариалсан талбайн хэмжээ, ажилчдын тоо нь 4 хувийн алдаатай буюу эерэг нөлөө үзүүлж байна. Ажилчдын тоо 10 хувиар өсөхөд ойролцоогоор 13 хувиар өсөж байна. Мөн талбайн хэмжээ 10 хувиар нэмэгдэхэд хураасан ургацын хэмжээ 6 хувиар өссөн байна.

Харин хураасан ургац, 1 га-ийн ургац, урамшуулал нь эерэг нөлөөтэй боловч статистикийн хувьд найдвартай биш гэж гарч байна. Урамшууллын хэмжээг нэмэгдүүлж хорогдуулсан ч ургац хураалт, ажилчдын тоо, талбайн хэмжээнд нөлөө үзүүлэхгүй гэж гарч байна. Өөрөөр хэлбэл урамшууллын үр ашиг бага байна.

## ДҮГНЭЛТ

Монгол Улсын ХАА-н салбарт 2010-2020 онд нийт 1 их наяд 93,3 тэрбум төгрөгийн татаас, дэмжлэгийг улсын төсвөөс үзүүлсэн байх бөгөөд үүний 75.3 хувийг МАА-н салбарт, 24.7 хувийг газар тариалангийн салбарт зарцуулсан байна. Нийт татаас, дэмжлэгийн 62.8 хувь нь мөнгөн урамшуулал, шилжүүлэг, 37.2 хувийн мөнгөн бус дэмжлэг байна. *(Хөдөө аж ахуйн дэмжлэг, урамшууллын судалгааны тайлан 2023 он)*

Судалгаанаас харахад улаан буудайн урамшууллын зорилго нь хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн болох гурилын нийлүүлэлтийг нэмэгдүүлж хэрэгцээг дотоодоосоо хангахад чиглэгдэж байгаа ба улаан буудайн дотоодын нийлүүлэлт нэмэгдэж байгаад урамшууллаас гадна засгийн газраас тариаланчдад үзүүлсэн түлш, шатахуун, бордоо, техник тоног төхөөрөмж, үр, хөнгөлөлттэй зээл зэрэг бусад хүчин зүйлс нөлөөлсөөр байна.

Орхон аймгийн газар тариалангийн салбарт аж ахуй эрхэлдэг 154 иргэнийг хамруулан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, батлагдсан аргачлалын дагуу судалгааг хийж гүйцэтгэлээ. Судалгаанд оролцогчид нь газар тариалангийн салбарт аж ахуй эрхэлдэг, өнөөгийн бодит байдал, тулгамдаж буй бэрхшээл, онцлог, давуу талын талаар өргөн мэдлэгтэй, үнэлгээ өгөх чадамжтай иргэд байсан ба судалгааны асуулгын найдвартай байдал хангалттай сайн (0.951) байгаа нь тооцооллоор батлагдсан.

Судалгааны үр дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийлээ.

- Иргэд өрхийн тариалалтын хүрээнд төмс, хүнсний ногоо, хүлэмжийн ногооны тариалалт хийдэг бол үр тариа, тэжээлийн ургамлын аж ахуйг ихэвчлэн компаниуд эрхэлдэг жишиг байна. Судалгаанд давхардсан тоогоор 90.9% нь төмс, хүнсний ногоо, 64.9% нь төмс тариалагч өрх хамрагдсан бол 2.6 % нь үр тарианы компаниуд байна.
- Газар тариалангийн салбарт нөлөөлөгч 28 хүчин зүйлийг судалгаанд оролцогчдоор Лайкерт шкалын аргаар үнэлсэн бөгөөд “Олон улсын болон төрийн бус байгууллагуудын оролцоо дэмжлэг” гэсэн хүчин зүйл нь тариаланчдаас маш муу үнэлгээ авсан нь ХАА-н салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд тариаланч ногоочдод өгөөжгүй байдаг нь харагдаж байна.

- Лайкерт шкалын үнэлгээгээр 2.64-2.95 оноо буюу дунд үнэлгээтэй 4 хүчин зүйл байгаагаас “Дундын борлуулагчдын (ченжүүд) оролцоо” хүчин зүйл нь тариалан эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг эцсийн хэрэглэгч болон үйлдвэрлэгч нарт нийлүүлдэг үнэ цэнтэй оролцогчид гэж үзсэн. Тариалан эрхлэгчдийн үйл ажиллагаанд байгаль цаг уур, дэлхийн дулаарлын нөлөө төдийлэн хүчтэй сөрөг нөлөө үзүүлээгүй байна.
- Шинжилгээгээр эерэг нөлөөтэй хүчин зүйлд “Орон нутгийн засаг захиргааны байгууллагын дэмжлэг хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн үр дүн” орсон нь Орхон аймгаас авч хэрэгжүүлж буй газар тариалангийн салбарт оруулсан төсөл хөтөлбөр авч хэрэгжүүлж буй бодлого, хөрөнгө оруулалт нь тариаланчдад маш том дэмжлэг болсон.
- Шинжилгээгээр эерэг нөлөөлөх бусад хүчин зүйлд усалгааны систем, эрдэс бордооны хүрэлцээ, үр тарианы олдоц, борлуулалтын цэг салбарын хүрэлцээ эерэг нөлөө үзүүлсэн байна. Энэ нь өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 80% -ийн хямдралтай үр худалдан авдаг бол худаг ус, усалгааны системийн өнөөгийн байдалд тариаланчид боломжийн үнэлгээ өгсөн харагдаж байна.
- Регрессийн шинжилгээгээр хураасан ургац, 1 га-ийн ургац, урамшуулал нь эерэг нөлөөтэй боловч статистикийн хувьд найдвартай биш гэж гарч байна. Урамшууллын хэмжээг нэмэгдүүлэх эсвэл хорогдуулах нь ургац хураалт, ажилчдын тоо, талбайн хэмжээнд нөлөө үзүүлэхгүй гэж гарч байна. Өөрөөр хэлбэл, урамшууллын үр ашиг бага байгааг харуулаа.
- Улаан буудайн урамшууллын зорилго нь гурилын нийлүүлэлтийг нэмэгдүүлж, хэрэгцээг дотоодоос хангахад чиглэгдсэн ба 2023 оны байдлаар гурилын гол түүхий эд улаан буудайг дотоодоосоо бараг 100 хувь хангаж байна. Дотоодын нийлүүлэлт нэмэгдэж байгаа нь зөвхөн урамшууллын нөлөө биш бөгөөд Засгийн газраас тариаланчдад үзүүлсэн түлш, шатахуун, бордоо, техник тоног, төхөөрөмж, үр, хөнгөлөлттэй зээл зэрэг өөр олон хүчин зүйлс нөлөөлсөн байна.
- 2019 оноос эхлэн гурилын үнэ эрчимтэй нэмэгдсээр өнөөдөр нэг кг нь 4,150₮ болж 4 дахин нэмэгдсэн байна. Гурилын үнийн энэ өсөлт нь буудайн үнийн өсөлттэй ихээхэн хамааралтай байгаа ба энэ нь улаан буудайн урамшуулал олгох Засгийн газрын бодлого, зорилготой зөрчилдөж байгаа юм. Иймд, энэхүү нийцгүй байдлыг эргэн харж зөв шийдэл гарах нь зөв болов уу.



## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Монгол улсын Засгийн газраас эх орныхоо хэрэгцээт буудай, төмс, хүнсний ногоог дотооддоо үйлдвэрлэх, хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор гадаад, дотоодын олон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлуулан, хэрэгжүүлэн ажиллаж байна. Эдгээр төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтууд нь малчид, тариаланчдад хүрч байгаа эсэхэд цаашид хяналтыг сайжруулан ажиллах шаардлагатай байна.

Судалгааны үр дүнд дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна. Үүнд:

- Урт хугацаатай, эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн нөхцөлийг бий болгох;
- Өрхийн тариаланч, ногоочдын техник тоног төхөөрөмжийн чадавх муу байгаа тул түүнийг урт хугацаатай, хөнгөлөлтэй зээлийн санхүүжилтээр шийдэх;
- Зоорины хүрэлцээг шийдвэрлэх;
- Ногоочдын худаг ус, усалгааны системийг сайжруулах;
- Борлуулалтын тогтмол нийлүүлэгчдийн сувгийг бий болгож тариаланч, борлуулагчдын хоорондын уялдаа холбоог хангаж өгөх;
- Газар тариалангийн салбарын хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн оновчтой бодлого боловсруулж хэрэгжүүлэх зэрэг болно.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Б.Энх-Амгалан. (2018 он). *EVIIEWS 9* програмыг шинжилгээнд ашиглах нь. Улаанбаатар.

Кобб-Дугласын үйлдвэрлэлийн Функци (Nastis et al, 2012). (n.d.).

Мартинес, М. Х. (2014). *Кронбах альфа коэффициент*. Мадрид: Мадрид холбоо.

Орхон аймгийн ХХААГ-ын 2017-2022 оны жилийн гүйцэтгэлээр тайлан. (n.d.).

Орхон аймгийн ХХААГ-ын 2022 оны тайлан. (n.d.).

Үндэсний статистикийн хороо. (2023). *Хөдөө аж ахуй*.

<https://www.1212.mn/mn/statistic/file-library/bulletin>.

Хөдөө аж ахуйн дэмжлэг, урамшууллын судалгааны тайлан 2023 он. (n.d.).

Хүнс, хөдөө аж ахуйн яам. (2023). *Газар тариалан*. Retrieved from [www.mofa.gov.mn](http://www.mofa.gov.mn).

ХХААГ, О. а. (2018-2022). *Жилийн ажил тайлан*.